

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны ... дугаар  
сарын ..-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвөлгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажилтанд сургалт зохион байгуулах журмыг нэгдүгээр, давтан сургах хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Холбогдох ажилтны албан тушаалын тодорхойлолтод Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан чиг үүргийг тусган, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга /О.Алтансүх/-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга /С.Тунгалагтамир/-т даалгасугай.

4. Энэхүү тушаалыг 201.. оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

С.ЧИНЗОРИГ

## **СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажилтанд зориулсан /цаашид ажилтан/ гэх сургалт зохион байгуулахад энэхүү журмыг баримтална.

### **Хоёр. Сургалтын зорилго, зорилт**

2.1.Сургалтын зорилго нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажилтны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчид үйлчилгээг шуурхай, цогц, хүртээмжтэй, чанартай хүргэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ.

2.2.Хөтөлбөрийн зорилгыг хангах ажлын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1.сургалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах;

2.2.2.сургалтын орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.3.сургалтын явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

2.2.4. сургалтанд оролцогчдыг холбогдох хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх чадвартай болгох,

2.2.5.сургалтад хамрагдсан ажилтнуудыг гарын авлагаар хангах;

## **Гурав. Сургалт зохион байгуулах**

3.1.Сургалтыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяа Сургалт, судалгаа мэдээллийн төв зохион байгуулж, сургалт зохион байгуулах удирдамжийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга батална.

3.2.Сургалт, судалгаа, мэдээллийн төв нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан үйлчилгээг үзүүлэх үүрэг бүхий ажилтныг давтан сургах гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн үндэсний сургагч, багш нарын багийг бэлтгэнэ.

3.3.Үндэсний сургагч багш нарын багийн гишүүн нь хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн магистр, түүнээс дээш зэрэгтэй, хууль эрх зүй, нийгмийн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, насанд хүрэгчдэд зориулсан сургалтын арга, техникийг эзэмшсэн байна.

3.4.Үндэсний сургагч багш нарын баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан үйлчилгээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажилтны сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр жилийн төлөвлөгөө болон шаардагдах зардлын тооцоог гарган, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын тушаалаар батлуулна.

### **Хоёр. Сургалтын зохион байгуулалт**

2.1.Журмын 1.1 дэх хэсэгт дурдсан ажилтныг давтан сургах хөтөлбөрийн дагуу сургах ба сургалтыг жилд нэгээс доошгүй удаа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь сургалтыг өөрийн харьяа Сургалт, судалгаа, мэдээллийн төвийг түшиглэн үндэсний, бүсийн, орон нутгийн хэмжээнд, мөн цахим сургалт, зайны сургалт хэлбэрээр зохион байгуулна.

2.2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан үйлчилгээг Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

2.3.Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн байгууллагатай Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар гэрээ байгуулан, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

## **Гурав. Суралцагсдад тавих шаардлага**

3.1.Сургалтад хамрагдах ажилтан сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшсэн байна.

3.2.Суралцагч сургалт зохион байгуулагдах явцад бүрэн хамрагдана.

3.3.Сургалтад хамрагдан хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшсэн ажилтанд “Сургагч багш”-ийн гэрчилгээ олгоно.

3.3.1.“Сургагч багш”-ийн гэрчилгээний загварыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга батлана.

## **Дөрөв. Сургалтад тавигдах шаардлага**

4.1. Сургалт нь дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1. сургалт нь энэхүү журмын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн;

4.1.2. сургалт нь батлагдсан хөтөлбөртэй;

4.1.3.сургалтын зохион байгуулалт нь байршил, цаг хугацаа, давтамжийн хувьд оновчтой;

4.1.4.сургалтын үр дүнг бодитоор үнэлэх хяналт үнэлгээний арга, хэлбэр тодорхой;

4.1.5.сургалтад хэрэглэгдэх гарын авлагаар бүрэн хангагдсан;

4.1.6.сургалтыг явуулах сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг боловсруулан Хүүхэд, гэр бүл, хөгжлийн газрын даргын тушаалаар батлуулсан байхаас гадна, багшлах бүрэлдэхүүн, сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүнийг шаардлагад нийцүүлсэн

4.1.7.сургалт явуулахад шаардагдах кабинет, тоног төхөөрөмж, сурах бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүнээр хангагдсан

4.1.8.сургалтыг тус журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан хөтөлбөрийн загуу зохион байгуулж, сургалтын үргэлжлэх хугацаа 30-аас доошгүй цаг байх.

4.2.Сургалтад оролцсон ажилтанд дараах үр чадварыг эзэмшсэн байна.

4.2.1.архив, албан хэрэг хөтлөлт, цахим бүртгэлийг хөтлөх чадвар;

4.2.2.шаардлагатай хууль эрх зүйн болон үндсэн мэдлэг;

4.2.3.хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр ёс зүйг төлөвшүүлэх, шийдвэр гаргах, ажил төлөвлөх болон чиг үүрэгт заасан ажлын байранд томилогдон ажиллахад тавигдах шаардлага, ур чадвар;

ТӨСӨЛ

## ДАВТАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

**Хөтөлбөрийн зорилго:** Давтан сургалтын зорилго нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажилтны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчид үйлчилгээг шуурхай, цогц, хүртээмжтэй, чанартай хүргэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг сайжруулахад чиглэнэ.

**Хөтөлбөрийн зорилт:** Давтан сургалтын хөтөлбөр нь түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажилтны мэргэжлийн болон мэргэшлийн ур чадварыг сайжруулахад чиглэсэн онол, практикийн мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх, ажил, мэргэжлийн холбогдолтой хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах арга зүйн асуудлыг хамарсан байна.

### Хоёр. Нийтлэг шаардлага

2.1. Давтан сургалтын хөтөлбөрт дараах нийтлэг шаардлага тавигдана.

2.1.1. ажлын байрны чиг үүрэгт нийцсэн зорилтот бүлгийн мэргэжил, арга зүй, хөгжлийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан;

2.1.2. сургалтын арга зүйг тодорхойлон, оролцогчдын мэдлэг чадвар, туршлага, хандлагыг хүндэтгэсэн, түүнд тулгуурласан;

2.1.3. мэдээлэл технологид суурилсан, туршлага, үр дүнгээ харилцан хуваалцах, шинэ санаачлагыг дэмжсэн;

2.1.4. зайны сургалтын дэвшилтэт арга, технологи, цахим хэрэглэгдэхүүн, тэдгээрийг хэрэгжүүлэх орчин нөхцөлд тавигдах шаардлага нь тодорхой ;

2.1.5. сургалтад хэрэглэгдэх болон бие даан судлах ном, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт үүсгэсэн;

**Гурав. Давтан сургалтын хөтөлбөрийн агуулга**

<b>Сэдэв</b>		<b>Цаг</b>	<b>Сургалтын агуулга</b>
<b><i>Нэг. Мэргэжлийн болон мэргэшлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх сургалт</i></b>			
1	Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын онол, арга зүйн асуудал	2	Нийгмийн ажлын онол, арга зүйн үндэс болон тогтолцооны болон экологийн, хэрэгцээний, зөрчилдөөний, солилцооны зэрэг онолууд.
2	Гэр бүлийн боловсрол, түүний агуулга, хамрах хүрээ	2	Гэр бүлийн боловсролын талаарх ойлголт, түүний ач тус, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн эдийн засаг, гэр бүлийн харилцаа, гэр бүл дэх жендер, гэр бүлийн эрх зүйн талаар мэдлэг ойлголт.
3	Асуудал бүхий /зөрчил маргаантай, хүчирхийлэлтэй, архины хамааралтай, өрөөсгөл буюу өрх толгойлсон эх, эцэгтэй, ядууралтай, хөгжлийн бэрхшээлтэй гишүүн бүхий гэх мэт/ гэр бүлтэй ажиллах арга зүй.	2	Янз бүрийн асуудалтай гэр бүлтэй ажиллах арга зүйн талаар ойлголт, мэдлэг.
4	Хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, үйлчилгээ	2	Хохирогчийн аюулгүй байдлыг хангах шаардлага хэрэгцээг тодорхойлох, хамгааллын аюулгүй байдлын үйлчилгээний хэлбэрийн талаарх мэдлэг.
5	Хохирогчийн нөхцөл байдалд үнэлгээ хийх	2	Хохирогч болон ар гэрийн талаар нөхцөл байдлын цогц үнэлгээ хийх аргачлал, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах дадал.
6	Хохирогчид нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх	2	Хохирогчид шаардлагатай нийгмийн халамжийн боломжит үйлчилгээний сонголтуудыг хууль эрх зүйн хувьд тодорхойлж сурах чадвар.
7	Хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх	2	Хүүхэд хамгаалал, хамгааллын үйлчилгээний төрөл хэлбэрийн талаарх ойлголт, мэдлэг.

8	Хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	2	Хохирогчид сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх арга хэлбэр, чадавхи.
	<b>Нийт цаг</b>	<b>16</b>	
<b><i>Хоёр. Ажил, мэргэжлийн холбогдолтой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга зүйн сургалт</i></b>			
9	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах	2	Тухайн хуульд заасан үйлчилгээ, чиг үүргийн талаар таниулах.
10	Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	2	Тухайн хуульд заасан үйлчилгээ, чиг үүргийн талаар таниулах.
11	Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах	2	Тухайн хуульд заасан үйлчилгээ, чиг үүргийн талаар таниулах.
12	Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	2	Тухайн хуульд заасан хариуцлагын тогтолцоог таниулах.
13	Эрүүгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	2	Тухайн хуульд заасан хариуцлагын тогтолцоог таниулах.
14	Холбогдох журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллах	2	Холбогдох журмуудын хэрэгжилтийг хангахад чиглэсэн арга хэмжээ үйл ажиллагаа, үйлчилгээ, хэм хэмжээг хэрэгжүүлж хэвших.
	<b>Нийт цаг</b>	<b>12</b>	
<b><i>Гурав. Дадлагын сургалт</i></b>			
15	Ажилтнуудын өөрийгөө хамгаалах чадвар, аюулгүй байдал, стресс менежментийн сургалт;	2	Үйлчилгээ үзүүлэгчдийн аюулгүй байдал, эрсдлийг тооцох, даван туулах чадвартай болгох.
	<b>Нийт цаг</b>	<b>30</b>	

Сургалтын нийт цаг нь 30 цаг байхаар тооцно.



## ТАНИЛЦУУЛГА

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажилтныг давтан сургах сургалт зохион байгуулах журам” –ын төсөл боловсруулсан тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах”; 13.1.2-т “энэ хуулийн 13.1.1-д заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг давтан сургах хөтөлбөр болон сургалт зохион байгуулах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих” чиг үүргийг Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу энэхүү журмын төслийг боловсруулав.

Журмын төслийн зорилго нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажилтны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчид үйлчилгээг шуурхай, цогц, хүртээмжтэй, чанартай хүргэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, батлагдсан хөтөлбөрийн дагуу тасралтгүй суралцуулах, сургалтыг тодорхой чиглэлийн хүрээнд батлагдсан агуулгын дагуу зохион байгуулахад оршино.

2016 оны 12 сард батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах зарчимд нийцүүлсэн.

Манай улсад 2005 оноос өмнө Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын харьяа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр нийслэлд болон Дундговь аймагт ажиллаж байсан бол өнөөгийн байдлаар төр болон ТББ-ын харьяанд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчод зориулсан нийт 8 хамгаалах байр, 14 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна.

Цаашид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нийгэмд тулгараад байгаа энэхүү асуудлыг бодлого зохицуулалтаар шийдвэрлэх үүрэг бидний өмнө тулгараад байгаа бөгөөд тус төвүүдэд ажиллах салбар дундын мэргэжилтнүүдийг бэлтгэх, мэргэшүүлэх зүй ёсны шаардлага үүсээд байна.

Иймээс журмын төсөлд давтан сургалтын хөтөлбөрийн агуулгыг мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, ажил мэргэжлийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга зүйн, дадлагын сургалт гэсэн 3 үндсэн хэсэгтэй байхаар боловсруулаад байна.

ТӨСӨЛ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**